



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 20 өдөр

Дугаар А/202

Булган сум

**“BULGAN GREEN MECH-2026” тэмцээн
зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны IV хуралдааны аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны “Булганы сэргэлт хөтөлбөрийг батлах тухай” IV/25 дугаар тогтоол, Аймгийн Засаг даргын 2026 оны “Хөтөлбөр, төлөвлөгөө, арга хэмжээний зардлыг батлах тухай” А/97 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “STEAM” үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд ШИМТ хөтөлбөрийн хэрэглэгдэхүүнийг сургалт, үйл ажиллагаандаа хэрэгжүүлдэг цэцэрлэгүүдийн дунд “BULGAN GREEN MECH-2026” тэмцээн зохион байгуулахад хөрөнгө, санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2. Дэмжлэг үзүүлэхэд шаардагдах 2,000,000 (хоёр сая) төгрөгийг “STEAM” үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Д.Эрдэнэбилэг)-д зөвшөөрсүгэй.

3. Тэмцээнийг үр дүнтэй зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Боловсролын газрын дарга (Ц.Цолмонбаатар)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Д.ҮРЭВ-ОЧИР

